

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2020 оны 07 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл 2020 оны эхний хагас жилд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

НЭГ.ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 309, 2020 оны 82 дугаар тогтоолоор шинэчлэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Харьяа агентлаг, байгууллагын дарга, дэд дарга, захирлын албан тушаалын тодорхойлолтыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/14 дүгээр тушаалаар батлуулан хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын дарга, тэргүүн дэд, дэд дарга, захирал, тус яамны албан хаагчдын 2020 оны ээлжийн амралтын хуваарийн санал авч Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/34, Төрийн нарийн бичгийн даргын А/07 дугаар тушаалаар тус тус батлуулан хяналт тавин ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар ажлын үр дүнгийн үнэлгээг үндэслэн яам болон харьяа агентлаг, байгууллагын 43 албан хаагчийн төрийн захиргааны зэрэг дэвийг ахиулж, шинээр олголоо.

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан журам, дүрмийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус яаманд мөрдөж буй Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулсан.

“Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2019 оны 11, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл батлах тухай” 2019 оны 275 дугаар тогтоолд нийцүүлэн Төрийн нарийн бичгийн даргын “Албан хаагчдыг чөлөөлж, томилох тухай” 2020 оны Б/21 дүгээр тушаалыг батлуулсан.

Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл батлах тухай” 275, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам батлах тухай” 2018 оны 382, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны 472, “Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох тухай” 2020 оны 75 дугаар тогтоолыг үндэслэн зэрэглэл батлах тухай” 2019 оны 275 дугаар тогтоолд нийцүүлэн Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны Б/23 дугаар тушаалаар албан хаагчдын цалинг шинэчлэн батлуулсан.

Төрийн албаны мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн 10 албан хаагчийг Төрийн жинхэнэ албаны тангараг өргүүлэх ажлыг 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулав.

ХОЁР.САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

Тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл 2020 оны эхний хагас жилд 2 удаа хуралдаж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ХЗДХЯ-ны албан хаагчдын 2020 оны дотоод сургалтын төлөвлөгөө, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг тус тус хэлэлцэн баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, яам болон харьяа байгууллагын албан хаагчдын 2019 оны хүний нөөцийн хөдөлгөөний тоо бүртгэлийн мэдээг 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

- 1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны төлөвлөгөөг хэлэлцэн батлах
- 2.ХЗДХЯ-ны албан хаагчдын 2020 оны дотоод сургалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
- 3.Хууль зүй, дотоод хэргийн яамны албан хаагчдад зориулсан “Нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2020 онд хийх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэлэлцэн батлах
- 4.Төрийн захиргааны албан хаагчдын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээг үндэслэн зэрэг, дэв, цалингийн шатлал нэмэгдүүлэх тухай
- 5.Зарим албан хаагчдаас гаргасан гомдлын тухай
- 6.Зарим албан хаагчийг тангараг өргүүлэх тухай
- 7.Архивын ерөнхий газраас ирүүлсэн хүсэлтийн тухай
- 8.Зарим албан хаагчдыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар уламжлах
- 9.Зарим албан хаагчдад төрийн захиргааны зэрэг, дэв олгуулахаар Төрийн албаны зөвлөлд уламжлах

Хуралдааны тэмдэглэлийг хөтөлж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолын төсөл 8-ыг боловсруулан батлуулсан. Хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг тооцон хяналт тавин ажилласан.

Албан хаагчдын дэлгэрэнгүй судалгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн харьцуулсан танилцуулгыг бэлтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн нарийн бичгийн даргын Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан уулзалтад танилцуулах тус яамны Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх танилцуулгыг бэлтгэсэн.

Салбар зөвлөлөөс харьяа агентлаг, байгууллагад Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай холбоотой мэдээ, мэдээлэл өгч, зөвлөмж, чиглэл хүргүүлсэн.

Тус яаманд шинээр томилогдсон 4 ажилтны товч мэдээллийг бэлтгэн Able дотоод сүлжээнд байршуулан нийт албан хаагчдад танилцуулсан.

ГУРАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХҮРЭЭНД

Төрийн албаны Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим системд оруулах мэдээллийг шинэчлэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Тус яамнаас яам болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхээр төлөвлөн ажиллаж, холбогдох байгууллагатай гэрээ байгуулсан. Уг програмд яам, харьяа агентлаг байгууллагын одоо ажиллаж албан хаагчийн талаарх болон нөөцөд байгаа удирдах болон гүйцэтгэх албан хаагчийн мэдээллийг оруулснаар хүний нөөцийг сургаж хөгжүүлэх, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг хангах, хариуцлага тооцох, хүний нөөцийн бодлогыг оновчтой төлөвлөх ач холбогдолтой юм. Энэ ажлын хүрээнд төрийн албаны “чадахуйн зарчим /мерит/”-д үндэслэн удирдах албан тушаалд ажиллах боломжтой албан хаагчдын судалгааг гаргасан.

Тайлангийн хугацаанд холбогдох дүрэм, журмын дагуу 3 албан хаагч сэлгэн, 1 албан хаагчийг дэвшүүлэн томилсон.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн 2020 оны 05 дугаар сарын 13-15, 06 дугаар сарын 08-10-нд нийтэд зарлан, 2020 оны 05 дугаар сарын 20, 06 дугаар сарын 15-нд сул орон тооны тусгай шалгалтыг зохион байгууллаа. Төрийн албаны тусгай шалгалтад орж тэнцсэн 6 иргэний дүнг нэгтгэн танилцуулж, тухайн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолыг Архивын ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төвийн захиралд хүргүүлэв.

Төрийн албаны зөвлөлөөс өгсөн чиглэлийн хүрээнд Нийслэлийн архивын газрын үйл ажиллагаатай танилцан, Төрийн албаны тухай хууль, журам дүрмийн хэрэгжилтийг шалган дүнг илтгэх хуудсаар Төрийн албаны зөвлөлд танилцуулсан.

ДӨРӨВ.ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ БОЛОН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Албан хаагчдын 2020 оны дотоод сургалтын төлөвлөгөө, ХЗДХЯ-ны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг тус тус хэлэлцэн Салбар зөвлөлийн 02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Дэлхий даяар тархаад байгаа коронавирусийн улмаас төлөвлөгөөт сургалтууд хойшлогдож, зарим сургалт онлайнгаар зохион байгуулагдсан. Удирдлагын академиас зохион байгуулсан мэргэшүүлэх тэргүүн түшмэлийн багц цагийн сургалтад 1, эрхэлсэн түшмэлийн багц цагийн сургалтад 9, ахлах түшмэлийн багц цагийн сургалтад 26, дунд хугацааны сургалтад 7, шинээр томилогдсон албан хаагчийн сургалтад 2 албан хаагч хамрагдсан.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа сургалтад хамрагдах албан хаагчийн нэрсийг гарган цахим бүртгэлд оруулав.

Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт сургалт, Австралийн MASP хөтөлбөрийн тэтгэлэгт сургалтыг нийт албан хаагчдад нээлттэй мэдээлж, танилцуулах ажлыг зохион байгуулав. Япон Улсын Засгийн газрын “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт сургалт”-ын төлөөлөгчийн газрын холбогдох хүмүүстэй уулзалт зохион байгуулж, цаашид албан хаагчдыг сургах чиглэлээр санал солилцов.

Тус яамны хуульчийн гэрчилгээтэй албан хаагчдын судалгааг гарган Монголын Хуульчдын холбоонд хүргүүлэв.

Төрийн албаны зөвлөлөөс зарласан “Бодлогын инноваци-2020” төслийн сонгон шалгаруулалтад тус яамны албан хаагчдын багийн “Байгууллагын соёлыг зан үйлд нөлөөлөх чадварын аргаар өөрчлөх нь” сэдэвт төсөл шалгарсан.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд яам болон салбарын хэмжээнд “Алба хаагч бүрт-орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн яам, Архивын ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн албан хаагчдын 390 айлын орон сууцанд албан хаагчдыг хөнгөлөлттэй үнээр оруулах ажлыг зохион байгуулж, зарим албан хаагч, өндөр настанд ХЗДХС-ын тушаалаар мөнгөн дэмжлэг үзүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар ажлын үр дүнгийн үнэлгээг үндэслэн яам болон харьяа агентлаг, байгууллагын 43 албан хаагчийн төрийн захиргааны зэрэг дэвийг ахиулж, шинээр олгож, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 7 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоосон.

ТАВ.ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны 03 дугаар тогтоолоор тус яамны Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Ёс зүйн зөвлөл тайлангийн хугацаанд 2 гомдол мэдээлэл хүлээн авч, журамд заасны дагуу хянан шалгах ажиллагаа хийж, дүгнэлт гаргасан.

Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр харьяа байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн. Энэ хүрээнд байгууллага бүр албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажилласан. Тухайлбал, ажлын хариуцлагыг сайжруулах хүрээнд Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчдөд Өрхийн амьжиргааны түвшин нь ядуурлын шугамаас дээш үнэлэгдсэн иргэдэд хууль зүйн туслалцаа хүссэн иргэдийн өрхийн амьжиргааны баталгаажих түвшний мэдээллийг холбогдох мэдээ, тайланд тусгаж ажиллахыг үүрэг болгосон. Оюуны өмчийн газраас албан хаагчийн ёс зүй, сахилга бат, хувийн соёлын талаарх зааварчилгааг тусгасан “Санамж” гарган, албан хаагчдаар гарын үсэг зуруулан зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцохоор заасан.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ